



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 1129

Улаанбаатар хот

Эд хөрөнгийн үзлэг, тооллого зохион байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоол, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажил эхэлсэнтэй холбогдуулан эд хөрөнгийн үзлэг тооллогын ажлыг зохион байгуулан ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Даваахатан  
(Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга)

Гишүүд:

П.Мөнхзаяа  
(Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсийн мэргэжилтэн)  
Б.Ундармаа  
(Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтсийн мэргэжилтэн)  
Б.Түмэнжин  
(Агентлаг хариуцсан Ахлах нягтлан бодогч)  
Нарийн бичгийн дарга: С.Болдоо  
(Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хяналт, шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн)

2. Байгууллагын эзэмшил, ашиглалтад буй эд хөрөнгөнд үзлэг тооллого хийж, эд хөрөнгийн мэдээллийг <https://burtgel.pfsp.gov.mn/> тооллогын программд үнэн зөв, бүрэн гүйцэт оруулан тайлан, дүн мэдээг холбогдох газарт хүргүүлэн ажиллахыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл Ажлын хэсгийн ахлагч (Э.Даваахатан)-д даалгасугай

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ҮЗЛЭГ, ТООЛЛОГО ХИЙСЭН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС

2022.05.31

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” 9 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай” А/448 дугаар захирамжийг үндэслэн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны “Эд хөрөнгийн үзлэг, тооллого зохион байгуулах тухай” А/27 дугаар тушаалаар тооллогын комисс томилогдож, холбогдох дүрэм, журам стандартын дагуу үндсэн эд хөрөнгийг тоолж, баталгаажуулсан.

Тус тооллогын комисс нь эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг холбогдох журам, зааврын дагуу 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны хооронд зохион байгуулсан. Тус эд хөрөнгийн тооллогоор Машин тоног төхөөрөмж 32 нэр төрөл дүн 152,228.332, Тавилга эд хогшил 33 нэр төрөл дүн 52,400,148.34, Бусад биет бус 92 нэр төрөл 564,860.834, программ хангамж 3 нэр төрөл дүн 1,430.000, Авто тээврийн хэрэгсэл 179,800,000.00 мянган төгрөг, нийт 950,719,314.34 мянган төгрөгийн эд хөрөнгө тоологдлоо. Тооллогын хугацаанд дутагдсан болон бүртгэлгүй, илүүдэлтэй хөрөнгө байхгүй болно.


Тооллогын тайлан, мэдээг батлагдсан маягтын дагуу гарган нэгтгэж, төрийн өмчийн тооллогын цахим системд мэдээллийг стандартын дагуу шивж оруулан ажилласан.

Тооллогын комиссын ахлагч:



Э.Даваахатан

Гишүүд:



П.Мөнхзаяа

Б.Ундармаа

Б.Түмэнжин

Нарийн бичгийн дарга:



С.Болдоо